


БАТЛАВ.
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Н.ТАВИНБЭХ



Улаанбаатар хот Багануур дүүргийн 158 МВт чадалтай шинэ дулааны станцын зураг төсөл боловсруулах даалгавар

2024.11.12

Дугаар 2024/ЗД-30

Улаанбаатар хот

1. **Зураг төсөл боловсруулах үндэслэл:**

1.1. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.2.12 дахь заалт

2. **Барилга байгууламжийн байршил:**

Улаанбаатар хот Багануур дүүрэг 3-р хороо үйлдвэр хэсэг

3. **Объектын бүрэлдэхүүн, хүчин чадал, ажлын биеийн параметр**

3.1. Багануурын шинээр баригдах дулааны станц нь 58 МВт-ын 2 (QXF58-1.6/130/70-AII), 21 МВт-ын 2 (XLG35-1A 15D) байхаар (нийт суурилагдсан хүчин чадал нь 158 МВт) байх, цахилгаан тоног төхөөрөмжүүдийн суурилагдсан хүчин чадал нь 9000 кВт-ийн чадал бүхий иж бүрэн дулааны станц, барилга байгууламжийн хамт Үүнд:

3.1.1. Багануур уурхайн (илчлэг 3360 ккал/кг) нүүрсний шинж чанарт тохирсон, 58 МВт-ын 2 ширхэг, 21 МВт-ын 2 ширхэг хүчин чадалтай эргэлдэх буцламтгай үет шаталтын технологитой 4 иж бүрдэл усан халаалтын зуухыг туслах тоноглол /утаа сорогч, үлээх салхилуур, нүүрс тэжээгч, үнс баригч/ болон агаар, утааны хийн хоолойн хамт суурилуулах ажил,

3.1.2. Зуух, туслах тоноглолын автомат удирдлага /хянах, удирдах, тохируулах/-ын систем, хэмжих хэрэгсэл суурилуулах ажил,

3.1.3. Утааны хийн зам, яндангийн угсралтын ажил,

3.1.4. Цахилгаан хангамжийн угсралтын ажил,

- 3.1.6. Ус хангамж, ариутгах татуургын системийн угсралтын ажил,
- 3.1.7. Хими ус цэвэрлэгээний угсралтын ажил,
- 3.1.8. Сүлжээний насос, сүлжээний усны шугамын гаргалгааны ажил,
- 3.1.9. Дулааны станцын барилга байгууламж, дээрх туслах тоног төхөөрөмжийн барилгын ажил,
- 3.1.10. Халаалт агаар сэлгэлт агааржуулалтын систем,
- 3.1.11. Холбоо мэдээлэл, галын аюулгүй байдлын систем,

Ажлын биеийн параметр:

Сүлжээний усны даралт - 1.25 МПа,

Температурын график - 130/70°C

4. Барилгын үндсэн бүтээц, материал, бусад шаардлага

- 4.1. Дулааны станцын барилга;
Суурь - цутгамал төмөр бетон
Хучилт - цутгамал төмөр бетон,
Каракас - металл,
Хана – цутгамал, тоосгон эсвэл сэндвич байж болно.

4.2. Дулааны суваг, ДДТөв /БНБД-ийн шаардлагаар/

5. Инженерийн байгууламжийн бүрэлдэхүүн буюу ажлын зураг төслийн бүрдэл

- 5.1. Цахилгаан хангамж: “БНЗӨБЦТС” ТӨХК-аас олгох Техникийн нөхцөлийн дагуу
- 5.2. Усан хангамж: “Багануур” ХК-ийн Ус шүүрүүлэх станц (нэмэлтээр усны нөөцийг гүний худгаар шийдэх)
- 5.3. Бүтээгдэхүүний холболтын цэг: ЭХЯ-аас олгох Техникийн нөхцөлийг үндэслэн, дээрх ажлын зураг төслийн гүйцэтгэлийн шатанд хэрэглэгчидтэй холбох холболтыг гаргана.

Зураг төслийн бүрдэл:

- Дэвсгэр зургийн тодруулалт
- Геологийн дүгнэлт
- Иж бүрэн ажлын зураг

- Батлагдсан төсөв
- Ажлын тоо хэмжээний жагсаалт
- Магадлалын ерөнхий дүгнэлт

- | | |
|--|--|
| 6. Галын аюулгүй байдлын нөхцөл | 6.1 Барилга, байгууламжийн галын аюулгүйн байдал БНБД 21.01.02
6.2 Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм БНБД 21.02.02 |
| 7. Эдийн засгийн тооцоо, төсөв | Төсвийг ESTIMATOR-PRO программ болон түүнтэй дүйцэхүйц зохиох эрх бүхий байгууллагын зөвшөөрсөн бусад программаар тооцно. |
| 8. Зураг төсөл зохиох үе шат, хугацаа | 8.1.Бэлтгэл ажил /инженер геологийн дүгнэлт, түүнтэй дүйцэх судалгаа/

8.2.Ашиглагч байгууллагатай зургийн тодруулга хийх

8.3.Зураг төсөл боловсруулах

8.4.Ажлын зураг хийж экспертизээр баталгаажуулах

8.5.Хяналтын төсөв хийх |
| 9. Цаашид өргөтгөх эсэх | Үгүй |
| 10 Барих хугацаа | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон, гэрээ байгуулна. Гэрээний хугацаанд угсралтын ажлыг гүйцэтгэнэ. |
| 11 Зураг төсөл боловсруулах хугацаа | Гэрээнд заасан хугацаанд |
| 12 Гүйцэтгэгч байгууллага | Ажлын параметрт дүйцэхүйц зуух, даралтат сав, шугам хоолой угсрах тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий барилга угсралтын байгууллагаар гүйцэтгүүлнэ. |
| 13 Захиалагч байгууллага | Эрчим хүчний яам, |
| 14 Зургийн байгууллага | Ажлын параметрт дүйцэхүйц зуух, даралтат сав, шугам хоолойн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлнэ. |

**15 Зураг төсөл
боловсруулахад
ашиглах материал**

Одоо мөрдөгдөж буй:

- Эрчим хүчний тухай хууль, Барилгын тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд
- Үйлдвэрлэлийн барилгын БНБД-үүд,
- Техникийн нөхцөлийн тусгай заалтуудад тусгагдсан цахилгаан байгууламжийн талаарх стандарт, норм дүрмүүд
- Галын аюулгүй байдлын дүрэм, норм стандарт
- Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм,
- Цахилгаан байгууламжийн дүрэм
- Даралтат сав шугам хоолойг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм
- Уур усны шугам хоолойг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм
- Стандартууд, төсөв зохиох аргачлалууд
- Бусад холбогдох дүрэм, журмууд
- Техник эдийн засгийн үндэслэл

**16 Зураг төслийн
санхүүжилт**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар

**17 Онцгой нөхцөл,
нэмэлт ажил**

- 17.1 Зураг төсөл, төсөв боловсруулах явцад зайлшгүй шаардлагаар захиалчийн зүгээс нэмэлт өөрчлөлтийг харилцан тохиролцсоны үндсэн дээр оруулж болно.
- 17.2 Эрчим хүчний хэмнэлттэй, ашиглалтын зардал багатайгаар төлөвлөнө.
- 17.3 Газар хөдлөлтийн балл: /Багануурын цуг уурын өртөөнөөс авах/
- 17.4 Хур тунадасны үзүүлэлтүүдийг харгалзан үерийн усны хамгаалалтыг төлөвлөх
- 17.5 Инженер геологийн дүгнэлтийг үндэслэн хөрсний усны хэлбэлзлээс үүсэх эрсдэлийг тооцоолон хамгаалах арга хэмжээнүүдийг холбогдох норм, дүрэм, зааврын дагуу төлөвлөх
- 17.6 Дулааны станцын барилга, дулааны шугам сүлжээний төлөвлөлтийг “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм”-ийн шаардлагын дагуу төлөвлөх


17.7 Аваар ослын үед аврах гарц төлөвлөх

17.8 Барилга угсралтын ажлын явцад зам, бут сөөг эвдэх тохиолдолд тэдгээрийг сэргээх зардлыг төсөвт тусгах.

Жич: Холбогдох материалыг хавсаргав.

1. “Багануурын Дулааны станц” ТӨХК-ийн ТЭЗҮ 2021-12-14 файл

ХЯНАСАН:

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ГАЗРЫН ДАРГА  Б.ЕРЭН-ӨЛЗИЙ

БОЛОВСРУУЛСАН:

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ГАЗРЫН СТРАТЕГИ, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН
АХЛАХ ШИНЖЭЭЧ  Б.БАТТӨМӨР